

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянтал сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2025/002/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Говьсүмбэр аймаг  
2025 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа  
Утас: 70543179

Цахим хаяг: [sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Наранбаяр

Цахим хаяг: [nananbayarg@audit.gov.mn](mailto:nananbayarg@audit.gov.mn)

Аудитор: Г.Ариунцэцэг

Цахим хаяг: [Ariuntsetsegg@audit.gov.mn](mailto:Ariuntsetsegg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2025.03.25 № 54  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
БАЯНТАЛ СУМЫН ТӨСВИЙН  
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ  
Э.БАТТУЛГА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан 4 байгууллагын нийт зөрчил 108.0 сая төгрөг бөгөөд гол зөрчил болох сумын ЗДТГ-ын 35.8 сая, ОНХС-гийн 45.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй боловч санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9, 8.9.3, 15 дугаар зүйлийн 15.4, 15.4.2 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

422502238

Гол үндэслэл нь MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”:6 төрийн аудитын зарчим, 6.4.3.1.3 Санал дүгнэлт, 6.4.3.1.3.1 Хязгаарлалттай - Аудитор шалгах зүйлд багтсан материаллаг боловч өргөн тархаагүй тодорхой зүйлийн талаар хангалттай ба зохистой нотлох зүйл олж авах боломжгүй эсвэл зөвшөөрөхгүй байгаа нөхцөлтэй санал нийлэхгүй үед, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/66 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан АДБОУС 200 “Санхүүгийн аудитын зарчим” стандартын 64-т Аудитор нь дараах гурван төрлийн өөрчлөлттэй санал дүгнэлтийг гаргаж болно: хязгаарлалттай санал дүгнэлт - аудитор буруу илэрхийлэл дангаараа эсхүл нийлээд материаллаг боловч өргөн тархаагүй, эсхүл байж болзошгүй буруу илэрхийллийн талаар хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй гэж дүгнэсэн үед, 78-д Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж буй аудитор нь санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлж бэлтгэсэн эсэхэд санал дүгнэлт өгөхийн тулд түүний бүрэлдэхүүн тайлангуудын санхүүгийн мэлээлэл, нэгтгэлийн үйл явцын найдвартай байдлын талаар хангалттай, зохистой аудитын нотолгоог бүрдүүлэх шаардлагатай гэж заасан.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь дүгнэлтийн үндэслэлд дурдсан материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй байна. Байгууллагын удирдлагын зүгээс тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээ бүртгэж, хууль журмыг зөрчсөн урамшуулал, илүү цагийн хөлсийг олгож, ажил гүйлгээ хийсэн, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		874,492.4	820,337.5
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	352,075.4	427,356.6
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	211,486.3	149,822.5
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	7а, 7б	218.7	218.7
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	187,275.6	216,012.3
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	9а	12,465.0	26,927.5
360	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	10	110,971.5	0.0
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		1,459,023.0	2,729,831.1
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	1,459,023.0	2,729,831.1
39200	<b>Биет хөрөнгө</b>		1,380,200.0	2,443,581.1
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	13	78,823.0	286,250.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		2,333,515.3	3,550,168.6
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		2,893.7	32,910.9
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	2,893.7	32,910.9
41300	<b>Өглөг</b>	17а, 17б	2,893.7	32,910.9
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		2,330,621.6	3,517,257.8
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		2,330,621.6	3,517,257.8
51100	Засгийн газрын оруулсан капитал		756,504.8	756,504.8
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		828,550.4	2,015,186.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		745,566.4	745,566.4
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		2,333,515.3	3,550,168.6

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		1,885,385.2	3,162,853.2
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		219,867.7	392,493.0
110	<b>Орлогын албан татвар</b>		173,685.1	266,946.8
1100	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>		188,609.7	277,113.7
1101	<b>Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт</b>		-14,924.6	-10,166.8

113	Хөрөнгийн албан татвар		15,298.2	43,474.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж		30,884.4	82,071.2
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1а, 1б	162,452.9	467,708.8
120	Нийтлэг татварын бус орлого		162,452.9	467,708.8
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		1,503,064.5	2,302,651.5
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	1,376,364.7	1,976,865.2
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		1,376,364.7	1,976,865.2
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		1,332,199.7	1,946,169.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		461,303.7	708,223.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		59,358.3	86,702.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		92,487.3	474,230.7
2104	Хангамж, бараа материалын зардал		92,514.2	139,939.9
2105	Нормативт зардал		0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		6,520.4	17,800.0
2107	Томилолт, зочны зардал		5,704.0	14,076.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		441,925.4	57,912.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		172,386.3	447,283.6
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		44,165.0	30,696.0
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		509,020.4	1,185,988.0
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		34,392.8	0.0
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		474,627.6	1,185,988.0

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан** /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>		1,779,848.2	2,761,331.1
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		219,867.7	392,493.0

110	Орлогын албан татвар		173,685.1	266,946.8
1100	Хувь хүний орлогын албан татвар		188,609.7	277,113.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-14,924.6	-10,166.8
113	Хөрөнгийн албан татвар		15,298.2	43,474.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж		30,884.4	82,071.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		11,915.4	9,591.1
1181	Газрын төлбөр		6,523.8	5,820.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		12,445.2	66,659.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		56,916.0	66,186.6
120	Нийтлэг татварын бус орлого		56,916.0	66,186.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,503,064.5	2,302,651.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,232,657.2	1,666,907.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,232,657.2	1,666,907.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,131,736.4	1,581,577.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		457,511.6	727,045.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		56,475.0	87,606.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		95,576.2	474,230.7
2104	Хангамж, бараа материалын зардал		24,958.9	46,510.1
2105	Нормативт зардал		533.0	250.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		11,707.0	35,433.7
2107	Томилолт, зочны зардал		5,704.0	14,076.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		459,352.8	76,857.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		19,917.9	119,567.5
211	ХҮҮ		0.0	0.0
212	ТАТААС		0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		100,920.8	85,330.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		547,191.0	1,094,423.7

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		323,322.4	1,017,366.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		323,322.4	1,017,366.5
2200	Дотоод эх үүсвэрээр		323,322.4	1,017,366.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-323,322.4	-1,017,366.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-2,200.0	-1,776.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		2,200.0	1,776.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		221,668.6	75,281.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		130,406.8	352,075.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		352,075.4	427,356.6

#### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,855,994.0	1,855,994.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,855,994.0	1,855,994.0
9	Тайлант үеийн үр дүн	474,627.6	474,627.6
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,330,621.6	2,330,621.6
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,330,621.6	2,330,621.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	648.1	648.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,331,269.7	2,331,269.7
19	Тайлант үеийн үр дүн	1,185,988.0	1,185,988.0
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,517,257.8	3,517,257.8

**2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ мянган төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,936,343.40	2,690,019.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,762,573.40	1,672,165.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,663,635.40	1,586,671.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	781,492.80	727,046.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,259.10	87,606.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	484,500.00	474,230.66
2104	Хангамж, бараа материалын зардал	45,987.00	45,985.14
2105	Нормативт зардал	250.00	250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,114.00	48,113.70
2107	Томилолт, зочны зардал	13,424.00	13,416.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,037.20	80,857.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,571.30	109,167.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,938.00	85,493.87
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	69,153.90	69,144.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,784.10	16,349.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,061,503.30	1,016,077.79
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	112,266.70	1,776.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,936,343.40	2,610,409.47
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	946,260.00	946,260.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,720,419.50	1,618,592.85
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	269,663.90	45,556.61
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		232,663.94
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		153,054.19

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Т3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,941.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,941.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,585.50
2104	Хангамж, бараа материалын зардал	525.00
	Томилолт, зочны зардал	660.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,400.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,356.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,356.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,941.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,941.50

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 19.7 сая төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан бөгөөд энэ нь Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэдэг харьяа байгууллагуудын алдаа байна.

Аудитаар нийт 108.0 сая төгрөгийн 12 зөрчил<sup>2</sup> илэрснээс 24.5 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт, 56.6 сая төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага, 27.0 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнээс 82.2 сая төгрөгийн зөрчил нь харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байна.

Залруулагдаагүй нийт зөрчлийн 108.0 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлаас давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 25.9 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс 1 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 25.9 сая төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ.

#### **Харьяа байгууллагууд**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 1 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 101.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 19.7 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 24.5 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 56.6 сая төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1.1 сая төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Шилэн дансны тухай хууль, бусад хууль тогтоомжийн нийцлийн аудитаар нийт 14.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 9.6 сая төгрөгийн 4 албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4.9 сая төгрөгийн 7 зөвлөмж хүргүүлсэн байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү/

Өмнөх онтой харьцуулахад харьяа байгууллагуудын нийт зөрчлийн дүн төлбөрийн акт 20.1 сая төгрөгөөр өссөн, албан шаардлага 8.7 сая төгрөгөөр буурсан, зөвлөмж 0.8 сая төгрөгөөр буурсан, нийцлийн аудитын албан шаардлагын дүн 48.5 сая төгрөгөөр буурсан, зөвлөмжийн дүн 4.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

#### **3.1 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт.**

Төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт хүргүүлээгүй байна.

#### **3.2 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага**

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**3.2.1** Шилэн дансны мэдээллийн нэгдсэн системд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэлийг 3 удаа, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт оруулах мэдээллийг 2 удаа нийт 5 удаагийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. Өмнөх оны аудитаар сумын нэгтгэлд хамрагдсан газруудын шилэн дансны зөрчил буурсан хэдий ч давтагдан гарсан.

Энэ нь Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”, Засгийн газрын 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 1 дүгээр зүйлийн 1.1.3, 1.1.10 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сумын Засаг даргын нэгтгэлийн болон харьяа байгууллагуудын шилэн данс, цахим бүртгэлийн системийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, алдаа зөрчлийг бууруулах

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Дотоод хяналттай холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Сумын төрийн сангаар хянагдаж буй байгууллагуудын ажил гүйлгээнд тавих хяналт сул, хууль журамд нийцээгүй гүйлгээг баталгаажуулдаг, байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт муу

Энэ нь Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоол "Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив"-ын 1.1.1, 1.1.3, 1.1.5, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Сумын төрийн сангаар хянагдаж буй байгууллагуудын ажил гүйлгээнд тавих хяналтыг сайжруулж хууль журамд нийцсэн гүйлгээг баталгаажуулж ажиллах, байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах

#### **2. Орлогын данстай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:** Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелсэн боловч 4 нэр төрлийн татварын орлого 25.8 сая төгрөгөөр биелээгүй, хуулиар тогтоосон татварын орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.1, 23.8.2, 23.8.14, 23.8.15, 23.8.16, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1 дэх заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Сумын татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь бүрэн биелүүлж ажиллах

#### **3. Нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал**

Нэгтгэсэн тайлантай холбоотой зөрчил илрээгүй.

Дээрх албан шаардлагын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянтал сумын Засаг дарга												
Баянтал сумын ИТХ	1	0.2			1	0.2	1	0.2				
Баянтал сумын ЗДТГ	2	19.5			2	19.5	2	19.5				
Баянтал сумын ОНХС												
Баянтал сумын ХХС												
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>19.7</b>			<b>3</b>	<b>19.7</b>	<b>3</b>	<b>19.7</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баянтал сумын Засаг дарга	1	25.9					1	25.9				
Баянтал сумын ИТХ												
Баянтал сумын ЗДТГ	5	35.8	3	23.8	1	11.0	1	1.1				
Баянтал сумын ОНХС	5	45.4	1	0.7	4	44.6						
Баянтал сумын ХХС	1	0.9			1	0.9						
<b>Нийт</b>	<b>12</b>	<b>108.0</b>	<b>4</b>	<b>24.5</b>	<b>6</b>	<b>56.5</b>	<b>2</b>	<b>27.0</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Баянтал сумын Засаг дарга	1				1			
Баянтал сумын ИТХ	1						1	
Баянтал сумын ЗДТГ								
Баянтал сумын ОНХС								
Баянтал сумын ХХС	1	6.4			1	6.4		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>6.4</b>			<b>2</b>	<b>6.4</b>	<b>1</b>	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Баянтал сумын Засаг дарга	1						1	
Баянтал сумын ИТХ	1	0.2			1	0.2		
Баянтал сумын ЗДТГ	5	7.9			1	3.0	4	4.9
Баянтал сумын ОНХС	2				1		1	
Баянтал сумын ХХС								
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>8.1</b>			<b>3</b>	<b>3.2</b>	<b>6</b>	<b>4.9</b>
<b>Нийт дүн</b>	<b>27</b>	<b>142.4</b>	<b>4</b>	<b>24.5</b>	<b>11</b>	<b>66.2</b>	<b>9</b>	<b>32.0</b>

**5 .Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Аудитад хамрагдах	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр			
			Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		